

Ф.НИЦШЕГИЙН АНХНЫ БҮТЭЭЛҮҮДИЙНХ НЬ АГУУЛГЫН ЗАРИМ ОНЦЛОГ

Ц. Гомбосүрэн .МУИС. НШУС. Философийн тэнхим. профессор

Ф.Ницшегийн философи үзэл нь энэ сэтгэгчийн туулж ирсэн хувийн амьдралтай, түүнээ өөрөө хэрхэн үнэлж ирсэнтэй нягт холбоотой байдаг.

Намтрын товч мэдээ: Фридрих Ницше 1844 оны 10 дугаар сарын 15-нд Германы Рекене гэдэг жижиг тосгонд төржээ. 1888 оны 4 дүгээр сарын 10-нд Георг Брандест түүний бичсэн захидлыг судлаачид Ф.Ницшегийн намтрыг тогтоохдоо иш татсан байдаг.¹ Энэ захидалдаа Ф.Ницше бичсэнээр тэрээр эцгийн талаасаа польшийн тайж гаралтай, харин эхийн тал нь герман аж. Ф.Ницшегийн эмэг эх нь Веймар дахь Шиллер-Гётегийн хүрээлэлд байж, бас энэ эмэгтэйн ах нь Веймар дахь Генерал-суперинтендентийн албыг Гердерээс уламжлан авч байсан аж. Ф.Ницшегийн эцэг протестант шашны санваартан байжээ. Тэр хүн залуудаа насан эцэслэсэн гэнэ. Ф.Ницше Боннд, хожим нь Лейпцикт суралцаж, сонгодог филологийг сайн эзэмшсэн аж. Бас А.Шопенгауэрийн "Ертөнц бол хүсэл эрмэлзэл ба төсөөлөл мөн" гэдэг бүтээлтэй Лейпцикт танилцсан байна.

Тэр үеийн германы хамгийн гарамгай филологич эрдэмтэн Ричль оюутан Ницшег бүр профессорын албан тушаалд санал болгож бичсэн тодорхойлолтондоо: 39 жилийн турш намайг харсаар байхад өсөж хөгжсөн авъяаслаг залуус дотор ийм 24-хөн насандаа ингэж түргэн бойжсон филологичийг би мэдэхгүй юм. Энэ залуу эрүүл, чийрэг, эрчимтэй, биеийн ба сэтгэлийн тэнхээ ихтэй. Ер нь тэр хүссэн бүгдээ хийж чадна гэх мэт үнэлгээ өгчээ.² Улмаар Ф.Ницше Базелийн их сургуулийн сонгодог филологийн тэнхимд уригдан ажиллах болсон байна. Тэгээд энд Яков Буркхардтай сайн нөхөд болж, Рикард Вагнертай танилцсан зэрэг бол Ф.Ницшегийн цаашдын бүтээлч үйл ажиллагаанд нэг хэсэг хүчтэй нөлөөлсөн аж.

1876 онд Ф.Ницшегийн бие эрс муудсан аж. Түүнээс хойш бие нь сайжраагүй төдийгүй улам дордож, өөрийнх нь дурдсанаар толгойны өвчин жилд дор хаяж 200 удаа Ф.Ницшег тарчлаах болжээ. Гэвч тэрээр энэ хүнд үеүдэд оюуны эрчимтэй ажлаа огтхон ч орхиогүй байна. Ф.Ницше Брандест бичсэн захидалдаа дурдсанаар бол энэ өвчин бусад хүмүүсээс түүнийг онцгой болгон дэвшүүлж, эрэлхэг зоригий нь ундаргаж өгснөөрөө түүнд их өгөөж хайрласан гэнэ. Ф.Ницше биеэ муудсанаас хойш, бүр тодорхой хэлбэл 1879 оноос хойш Базелийн их сургуулийн профессороор ажиллахаа больж, өвчний шаналгаа, мөнгөний гачаал зэрэг байнгын бэрхшээлийг тэсвэрлэн байж бүтээлүүдээ нэгий нь нөгөөгийнх нь дараа тасралтгүй хэвлүүлж иржээ. Ингэхдээ зарим номоо өөрийнхөө зардлаар нийтлүүлж байлаа. Учир нь, Ф.Ницше философийн бүтээлүүдээ уран зохиолын хэлбэрт ойртуулсан өвөрмөц хэлээр бичиж, тэдгээрийнх нь агуулга ч гэсэн дэвшүүлсэн асуудал, шийдвэрлэсэн үр дүнгээрээ сонгодог философид байгаагүй санаа бүхий байсан тул хэвлэлийн эздийн уламжлалаа барьдаг сэтгэлд үл багтаж, тэд алдагдлаас айхдаа номыг нь зардлаараа хэвлэхээс болгоомжилдог байжээ.

1890 оны 8 дугаар сарын 25-нд Ф.Ницше нас барж, хувийн зардлаараа хэвлүүлсэн сүүлийн бүтээлийнхээ нэр цууд гарахыг мэдэлгүй өнгөрсөн аж.

Германы энэ гарамгай сэтгэгчийн нас барсны дараахь хувь заяа нь ч гэсэн амьд ахуйнхаас нь дутуугүй эмгэнэл туулж ирсэн байна. Философи үзэл санаа, түүнээ илэрхийлдэг бичлэгийн стиль нь хожим олон философи чиглэлийн төлөөлөгчдөд өнөөг хүртэл хүчтэй нөлөөлдөг билээ. Үүний зэрэгцээ түүний философи үзэл санааг гуйвуулан завшигчид цөөнгүй гарч ирсэн байна. Тухайлбал "Ницше бол фашизмыг үзэл санааны хувьд үндэслэгч мөн" гэдэг үндэслэлийг ялангуяа марксизмын хүрээний үзэл сурталчид хүчтэй сурталчилж иржээ. Ийм сурталчилгаанд Ф.Ницшегийн эгч, Ницшегийн үзэл санааны өвийг өмчлөгч, сурталчлагч Элизабет Ферстер-Ницше онцгой түлхэц өгсөн аж. Энэ эмэгтэй төрсөн дүү Ницшегээ германы ард түмний үндэсний сэргэн мандалтыг оюуны хувьд хошуучлагч гэж алдаршуулахыг хүсэж, түүнийг нь германы хэт барууны албан ёсны үзэл сурталчид өлгөж аваад фашизмыг оюуны хувьд үндэслэгчдийн нэг хэмээн Ницшег сурталчилсан байна.

Гэтэл угтаа Ф.Ницше бол европын сонгодог гуманизмын сүүлчийн төлөөлөгч мөн гэж зарим судлаачид, мэргэжлийн хүмүүс үздэг билээ. Үүнийхээ нотолгоо болгож тэд бичихдээ амьдрал бол маш далдлаг, хатуу ширүүн эмгэнэл мөн гэж Ф.Ницше өөрийн бүтээлүүдэд эмзэглэн дүрсэлж харуулсныг дурддаг юм(ийм дүгнэлтээ Ф.Ницшегийн "эзэрхэх хүсэл эрмэлзэл" гэдэг баримтлалд тэд бас хамааруулдаг). Бас Ф.Ницшегийн дэвшүүлэн тунхагладаг үлэмж хүн бол үндсэрхэг үзэлтэн (нацист) биш, тэр ч байтугай хамгийн хүчирхэг, баатарлаг хүн ч биш, харин хамгийн гол нь "буян, нүглийн замаар" байхыг хүсэж, шинэ хүн төрөлхтөн үүсэх нь гэдгийг тунхаглагч тийм философич мөн.³ Тухайлбал, Италийн философич Джованни Реале, Дарио Антисери нар Ф.Ницше бол фашист биш, нацист үзэлтэн биш гэж үздэгээ нотолж бичихдээ: Ф.Ницше Заратустрагийн үг болгож: "хүн төрөлхтөн ангижирвал зохих хамгийн муу нүглүүд дотор төрд сөгдүүлдэг нүгэл багтана", "аймшгуудаас хамгийн зэвүүн нь төр мөн" гэх мэтээр бичин өөрийнхөө санааг илэрхийлснийг дурдсан юм.⁴

Ф.Ницшегийн философи үзэл нь хэд хэдэн хувьслын зам туулсан байна. Үүнд: 1). Залуу Ницшегийн романтизм. Энэ үедээ тэрээр А.Шопенгауэр, Р.Вагнер (R.Wagner) нарын үзэл санааны нөлөөнд байж, соёлын туршлагыг романтик эстетикт, бүр тодорхой хэлбэл эртний Грекийн анхан үеийн урлагийн ноёрхогч хэв маягт тохируулан тайлбарлаж байжээ. 2). Р.Вагнерийн үзэл санаанд итгэхээ больж, мөн А.Шопенгауэрийн үзлээс татгалзах замд орж, "бүх үнэлэмжийг хянан шинэчлэх ёстой" гэдэг үзэлд шилжсэн үе. 3). Эрийн цээнд хүрсэн Ницшегийн үе. XIX зууны 80-аад оноос хойшхи хугацаан дахь энэ шатны сургаалд нь "эзэрхэх хүсэл эрмэлзэл", "үлэмж хүн" зэрэг А.Шопенгауэрийн нөлөөгөөр боловсруулсан философи баримтлалуудаас гадна "мөнхийн буцалт", "нигилизм" гэх мэт ойлголт чухал байр суурь эзэлдэг болсон байна.

Гэхдээ эл ангиллыг хожмын судлаачдаас өмнө хэрэг дээрээ Ф.Ницше өөрөө хувийн амьдрал, философи үйл ажиллагааныхаа үеүдийг тодорхойлохдоо бий болгосон гэж болохоор байдаг. Үүнтэй холбогдуулан дурдахад Ф.Ницше "Заратустра ингэж өгүүлэв" гэдэг бүтээлийнхээ 1883 онд бичсэн нэгдүгээр хэсэгтээ "Гурван хувирлын тухай" гэдэг өгүүллэг багтаасан

байдаг. Тэр өгүүлэгтээ Ф.Ницше өөрийнхөө үндэслэлийг Заратустрагийн үг болгон: "... ямар шүү байдлаар сэтгэл тэмээ болж, тэмээ нь арслан, арслан нь хүүхэд болдог тухай сэтгэлийн гурван хувирлыг та нарт нэрлэе"⁵ гээд тэмээ нь тогтсон үнэлэмжүүдээр тушуулж боловсрол, ёс суртахуун, соёлын дарамтыг тээж байдаг. Цөлд (өөрөөр хэлбэл хуучин үнэлэмжүүдээс ангид нөхцөлд-Ц.Г.) тэмээ арслан болж, тэр (арслан) нь өөрийг нь шүүмжилдэг тогтсон үнэлэмжүүдийн дарамтыг биеэсэ сэгсэрч унаган гишгичдэг. Арслан эцсийн эцэст хүүхэд болж хувирахад хүрдэг. Энэ хүүхэд бол шинэ шинэ үнэлэмж бүтээгч мөн.

Хүний сэтгэлд ийм хувирлууд байдаг гэсэн Ф.Ницшегийн энэхүү дүрслэл түүний өөрийнх нь амьдрал, эрүүл мэндийнх нь үеүүдийг илэрхийлдэг тухай зарим судлаач тодорхой тайлбарлаж иржээ. Тухайлбал францын философич Жиль Делез (G.Deleuze 1925-1995) Францын Руаймонд 1964 онд болсон философийн коллоквиумын үр дүнгээр бичиж, 1965 онд хэвлүүлсэн "Ницше" гэдэг бүтээлдээ энэ тухай тодорхой өгүүлсэн юм.⁶ Ж.Делез эл бүтээлдээ: Ф.Ницше 1878 онд бичсэн "Хүмүүнлэг, хэт хүмүүнлэг" зохиол "үнэлэмжүүдийг сүртэй шүүмжлэхийг, Арслангийн жилүүдийг нээжээ. Нөхөд нь Ницшег ойлгохоо байж, Вагнер дайрч давшлан харааж загнах болов. Хамгийн хэцүү нь тэрээр улам улам өвчинд нэрвэгджээ" хэмээн Ницшегийн хувийн амьдрал, философи үйл ажиллагааны нь үеүүдийг түүний философи үзлийнх нь хувьслаас хамааруулан зарим талаар тодотгосон аж.

Ж.Делезийн дүгнэлтээр Ф.Ницше: өвчин бол эрүүлийг ойлгох, эрүүл байх нь өвчнийг ойлгох ундарга мөн гэж үзэн, ийм үзлээ үнэлэмжийг хянан шинэчлэх аргаа болгожээ. Мөн Ж.Делезийн бичсэнээр Ф.Ницше "Заратустра ингэж өгүүлэв" гэдэг зохиолынхоо 4 хэсгийг бичсэн 1983-1985 онуудаас хойш шүүмжлэлийг урьд байгаагүй төвшинд хүргэж, улмаар түүнээ үнэлэмжүүдийг өөрчлөн хувиргах зэвсэг болгосон аж. Энэ бол сэтгэлийн гурав дахь хувирал буюу хүүхэд бий болсон үе юм.

Ф.Ницше өөрийн философидолтонд илэрхийллийн хоёр хэрэгслийг тууштай ашигладаг. Тэдгээр нь жич жич афоризм (онч үг), уран зохиол хоёр мөн (гэхдээ тэдгээрийг философи гэж биш, харин философидолтын хэрэгсэл гэж ойлгох ёстойг мартаж болохгүй). Тэдгээр хэрэгсэл нь Ф.Ницшегийн философи бол уламжлалт философиос өөр, шинэ хэв маягийн философи, тэрээр шинэ маягаар сэтгэгч болохынх нь чухал илрэл ба зайлшгүй хэрэгцээ болж өгсөн гэж үзэх үндэстэй (үүнтэй холбогдуулан дурдахад Ф.Ницше философи үзлийг цэгцтэй томоохон зохиолоор илэрхийлэх чадваргүйгээс афоризм хэрэглэдэг гэж зарим философич бичсэн нь үнэмшил төрүүлэх үндэслэгээгүй хуурай мэдэгдэл байдаг).

Уламжлалт философид танин мэдэхүйн чин эрмэлзэл, зорилго зэргийн тухай ярьдаг бол Ф.Ницше тэдгээрт тайлбар, үнэлгээ зэргийг сөргүүлэн дэвшүүлсэн байна. Энд тайлбар нь аль нэг үзэгдлийн жич, ангид "утгыг" бататгаж, харин үнэлгээ нь янз бүрийн утгын шаталсан үнэлэмжийг тодорхойлдог. Тайлбар нь ур дүй шаарддаг. Түүнд хамгийн тохиромжтой ур дүй Ф.Ницшегийн хувьд афоризм байдаг. Мөн түүний хувьд афоризм бас тайлбарын өгүүлэгдэхүүн болж өгдөг. Харин үнэлгээний өгүүлэгдэхүүн нь уран зохиол, ялангуяа шүлэг мөн гэж тэрээр философидоо баримталсан аж. Уран зохиол бол Ф.Ницшегийн хувьд бас үнэлгээний урлаг мөн.

Ийнхүү Ф.Ницшегийн философи бол иррационалист шинжтэй. Тэрээр өөрийн философийг ирээдүйн философи гэж тооцсон. Ирээдүйн философич бол түүний үзлээр тайлбарлагч ба үнэлэгч мөн. Ирээдүйн философич бол тайлбарлагчийн хувьд физиологич ба эмчлэгч, янз бүрийн үзэгдлийг жич жич байдлаар ажиглаад тэдгээрээ афоризмаар илэрхийлдэг мөн. Ирээдүйн философич бол үнэлэгчийн хувьд янз бүрийн "перспектив (дүрслэлийг)-ийг" ажиглан бүтээж, уран зохиолоор, ялангуяа шүлгээр ярьдаг уран бүтээлч мөн.

Ф.Ницшегийн дүгнэлтээр сэтгэлгээ, амьдрал хоёрын нэгдэл Сократаас хойш салсан. Иймд түүнээс хойш амьдрал шалигүй, сэтгэлгээ ухаалаг биш болсон аж. Угтаа амьдрал сэтгэлгээг идэвхжүүлдэг, сэтгэлгээ амьдралыг бататгадаг байх ёстой(тэрээр "амьдрал", "сэтгэлгээ" гэдэг хоёр ойлголтыг метафизикт ярьдгаас өөр утгатай хэрэглэснийг мартаж болохгүй).

Материализм, идеализм, диалектикийн янз бүрийн ойлголт, баримтлалуудын агуулгыг дэмжих юм уу үл зөвшөөрөх аль нэг байр сууринаас авч үзэхийг жинхэнэ философидох үйл ажиллагаа хэмээх явцуу итгэл үнэлэмжид автсан тийм уншигч ба холбогдох сургалт, сурталчилгаа, судалгаа эрхэлдэг хүмүүст Ф.Ницшегийн философидолт (ер нь сонгодог биш философийн аль ч чиглэл) өөрийнхөө жинхэнэ утгаар ойлгогдоно гэдэг эргэлзээтэй, шулуухан хэлэхэд бололцоогүй зүйл билээ. Үүнийг германы энэ сэтгэгчийн үнэлэмжийнх нь онцлог ба философийнх нь агуулга, үзэл санаагаа илэрхийлдэг арга маяг аль алинд холбогдуулан дурдаж байна. Ф.Ницше уламжлалт философийн зарим нэр томъёог ашигласан тохиолдолдоо, бас ерийн ухамсрын төвшинд утга нь тодорхой үгнүүдийг философи утга бүхийгээр ашиглахдаа тэдгээрт шинэ үнэлэмжийнхээ үүднээс шинэ утга оруулж ашигласны зарим баримтыг өмнө дурдсан билээ.

Ф.Ницшегийн үзэл санааны хувьсал бол XIX-XX зууны зааг үе дэх Европын оюуны амьдралын эдрээт шилжилтийн гэмээр нөхцлийн тодорхой үр дагавар мөн гэж зарим судлаач дүгнэсэн байдаг. Үүнд, нэгэнтэйгүүр Ф.Ницше бол эртний Грекийн үе, христос ёсны үе, сэргэн мандалт, шинэ үе хүртэлх хугацааны өрнөдийн оюуны соёлыг, ялангуяа урлаг, философи хоёрыг нь мэргэжлийн өндөр түвшинд ухааран эзэмшээд чухал чухал онолын дүгнэлт хийж, философдолтын шинэ хэв маягийг үлгэр жишээч бий болгосон хүн мөн. Нөгөөтэйгүүр тэрээр эвдэгч, улаан галзуу мэт, содон хурц, давшингүй сэтгэлгээгээрээ европын соёлд иррациональ хавчуургыг хүчлэн оруулж, үүгээрээ ялзруулагч, солиотой найрагч, хоосон лүндэн бууллагч гэж цоллуулдаг хүн юм.

Ийм өөр өөр үнэлгээг Ф.Ницшегийн бүтээлд янз бүрийн судлаач өгдөгт холбогдуулан Ж.Делез "Ницше" зохиолдоо дараахь анхааруулгыг багтаасныг иш татахыг тохиромжтой гэж үзлээ. Тэнд түүний бичсэнээр "Ницшег уншигч бид гарч болох дөрвөн алдаанаас зайлсхийдэг байх ёстой. Үүнд: 1). Эзэрхэх хүсэл эрмэлзэлд холбогдох (эзэрхэх хүсэл эрмэлзэл гэдэг бол "ноёлох гэсэн шунахайрал" буюу "засаг барих хүсэл эрмэлзэл" гэсэн утгатай хэмээн бодож болохгүй); 2). Хүчитнүүд ба сул доройчуудад холбогдох (ямар нэг нийгмийн байгууламж дахь хамгийн "чадвартнууд" нь хамгийн хүчитнүүд байдаг гэж бодож болохгүй); 3. Мөнхийн Буцалтанд холбогдох (грекчүүд, энэтхэгчүүд, египетчүүдээс зээлдсэн хуучин үзэл санааны тухай ярьж байна гэж бодож болохгүй бөгөөд орчлын тухай буюу Тэр юмны Өөрийнх нь Буцалтын тухай, тэр юманд өөрт нь эргэж орох тухай

ярьж байна); 4). Сүүлийн бүтээлүүдийнх нь тухай (тэдгээр бол жинхэнэ бүтээлийн хүрээнд багтахгүй буюу ердөө л солиорлоор гутаагдсан гэж бодож бодохгүй)"⁷.

Урлагийн ба ёс суртахууны философи үзлийн уялдаа. А.Шопенгауэрийн хүчтэй нөлөөнд байхдаа Ф.Ницшегийн бичсэн "Трагедийн төрөлт буюу эллиний соёл ба пессимизм", "Амьдралд түүхийн шинжлэх ухааны өгдөг ашиг хорын тухай" зэрэг бүтээлд⁸ хүн төрөлхтний оюуны соёлын зарим төрөлд сонгодог философийнхоос ялгаатай байр сууринаас, шууд хэлбэл волонтаризмын үүднээс үнэлгээ өгсөн байдаг. Түүний волонтаризм нь ёс суртахууныг үгүйсгэх үзэлтэй(аморализмтай) уялддаг. Тухайлбал, "Трагедийн төрөлт ..." бүтээлд: "ёс суртахууны (ялангуяа христосын, өөрөөр хэлбэл гарцаагүй ёс суртахууны) өмнө амьдрал ямагт заавал зөв биш байх ёстой. Учир нь, амьдрал бол мөн чанараараа ёс суртахуунлаг биш зүйл мөн"⁹ хэмээн бичсэн. Тэгээд Ф.Ницше ёс суртахуун бол "амьдралыг үгүйсгэхийн төлөөх хүсэл эрмэлзэл" мөн гэдэг дүгнэлт хийсэн байна.

Тийнхүү Ф.Ницшегийн тооцоогоор аморализм бол амьдралыг үзэн яддаг баримтлал биш, түүнд тодорхой хэм хэмжээ байх ёстойг үгүйсгэдэг үзэл биш, харин ертөнцийг үзэх уламжлалт үзлээс(тухайлбал христос ёсны үзлээс) огт өөрөөр амьдралыг ойлгох зарчим мөн. Тэгээд тэрээр дээрх бүтээлдээ ёс суртахууныг биш, харин урлагийг хүний метафизик үйл ажиллагаа гэж үзэх ёстой бөгөөд ертөнцийн оршихуй бол эстетик феномен (гоц үзэгдэл) гэж бичсэн байна.

Иррационалист философийн төлөөлөгчид амьдрал гэж юуг ойлгодог талаархи нийтлэг ойлгоцыг нь бид өмнө авч үзсэн билээ. Ф.Ницшед тэр ойлгоц холбогддог нь ойлгомжтой. Улмаар тэрээр: амьдрал бол хүн төрөлхтний өөр өөр иргэншилд тэрхүү иргэншилдээ харгалзсан хувь заяа болж илэрдэг гэж үзсэн. Тийнхүү тодорхой утгаар амьдрал бол хувь заяа мөн. Энэ хувь заяаг(амьдралыг) нээн илрүүлдэг хамгийн сайн хэрэгсэл нь түүнд ойр байдгаараа урлаг мөн гэж Ф.Ницше хичээнгүйгээр нотлон бичжээ. Урлаг бол жинхэнэ бодит байдлыг буюу амьдаралыг танин мэдэх үндсэн хэрэгсэл мөн гэж Ф.Ницше үзсэн нь тэрээр амьдралыг(А.Шопенгауэрийн адилаар) хатуу хахир, баримжаагүй иррациональ шинж, иймд амьдрал бол эмгэг, эвдрэл, эмгэнэл мөн гэж ойлгосонтой нягт уялддаг.

Хүний амьдралын ийм айхтар ээдрээг оюун ухаан нээдэг биш, бас бурхан тэнгэрт хандсан сүсэг бишрэл нээдэг биш, харин зөвхөн урлаг нээж чаддаг бөгөөд урлаг бас зовлонг сөрөх чадвартай ганц найдвартай соёлын төрөл мөн гэж Ф.Ницше үзсэн юм. Тийм баримтлалынхаа нотолгоо болгож эртний Грекийн олон шидэт домгийн (мифийн) агуулгад чухал чухал тайлбар хийжээ. Жишээ нь, тэрээр хүний амьдралын хувь тавилан ямар байдаг тухай өөрийн үзлийг илэрхийлэхдээ Эдип хааны тухай шидэт домгийг ашигласан байна.

Ф.Ницшегийн философи дүгнэлтэнд үндэслэгээ болж буй тийм үйл явдлуудыг Эдип хааны тухай шидэт домгоос онцолж доор дурдъя¹⁰.

Фива хотынхны хаан Лай нэг удаа Пелопс хааныг зочноор очоод буцахдаа хүү Хрисиппийг нь хулгайлан харьжээ. Үүнд гашуудах, хилэгнэн хорсох хоёр нь зэрэгцсэн Пелопс хаан: бурхан тэнгэр нар энэ хулгайчийг шийтгэхдээ хүүгээр нь түүнийг алуултугай гэж хараал хийжээ.

Лай хотдоо буцаж ирээд Жокаст гэдэг сурвалжит бүсгүйг эхнэрээ болгон суусан аж. Гэвч тэд суугаад олон жил болоход үр хүүхэд заяасангүй. Лай өөрсөддөө яагаад үр заяахгүй байгааг мэргэч төлөгчдөөрөө алдартай газар болох Дельфид очоод Аполлон тэнгэрээс асуужээ. Аполлоны тайлгач хариулсан нь: Бурхан тэнгэр нар хүсэлтийг чинь биелүүлж, чамд хүү заяана. Гэвч Пелопсын хараал чамд хүрч, хүүгийнхээ гарт чи үхнэ гэжээ.

Үүнийг сонссоноос хойш эхнэрээс нь хүүхэд гарч, тэр нь хүү байв. Аполлоны тайлагчийн үгийг мартаагүй Лай түүнийг төрсөн даруйд нь зарцдаа шилжүүлж, зэрлэг араатны идэш болгохын тулд ойд хаяхыг тушаажээ. Гэвч нарийн учрыг үл мэдэх зарц нь нярай амьтныг хаяж төвдөлгүй Коринфын хаан Полибын хоньчин боолд нууцаар өгсөн аж. Тэр нь уг хүүг Полиб хаанд аваачин өгөхөд үр хүүхэдгүй энэ хаан хүүг залгамжлагчаа болгохын тулд үрчилж авахаар болж, улмаар хатантайгаа хамжин хүүг ширээ залгамжлагчийн хүмүүжлээр өсгөн бойжуулж, эрийн цээнд хүргэжээ. Энэ хүү анх олдохдоо хөл нь хавдар, шархтай байсан тул Эдип(хавдар хөлт) гэдэг нэр түүнд өгсөн аж.

Эдип эр биед хүрсэн хойноо өөрийгөө өргөмөл бололтой гэж бусдын үгнээс сэжиг авчээ. Иймд тэрээр үнэнийг мэдэж авахаар хаан эцэг, эх хоёроосоо асуусан боловч тэд нь ямар ч тодорхой хариу хэлээгүй аж. Тэгэхээр нь Аполлон тэнгэрт очиж үүний тухай асуухад Аполлон тэнгэр: чи эцгээ алж эхтэйгээ ханилах аймшигт хувь заяатай юм байна гэж хариулжээ. Үүнийг сонсон цочирдсон Эдип ийм гутамшигт хувь заяанд унахгүйн тулд орон гэр, хотоо орхин, хандсан зүгтээ явсан байна. Учир нь, эцэг эх хоёр нь хэн бэ гэдгийг Эдипт Аполлон ч хэлээгүй тул Полиб, түүний хатан хоёрыг жинхэнэ эцэг эх минь байж болох юм гэж тэр болгоомжлоод ийм сонголтыг хийжээ.

Эдипийн явсан зүг нь хувь заяаны эрхээр фивачуудын нутаг байж тохиосон аж. Тэгээд Эдип фивачуудын нутагт маш нарийн хавцлын замаар явж байгаад хөсөг тэрэгтэй хүмүүстэй таарчээ. Түүнд хаан Лай сууж явжээ. Хөтөч нь Эдипийг муухай хараан, зам тавьж өг хэмээн түүнийг ташуураараа балбасан байна. Үүнд уур нь их хүрсэн Эдип хөсөг тэрэгний хажуугаар чихэлдэн гарахдаа таягаараа хөтчийг хүчтэй цохитол таяг нь хальтарч, Лай хааныг оножээ. Өвгөн хаан үхэтхийн унахдаа хавцлын уруу өнхрөн одсон ажээ. Улмаар зодоон цохион үүсэхэд хүч чадалтай Эдип бүгдийг дийлэв. Сэм зугатаж амжсан ганц зарц нь хотдоо очоод энэ уй гашууг мэдээлжээ. Үүнийг сонссон Жокастын ах Креонт хаан фивачуудыг хүүхэн цээжит, арслан бөгст, шувуун далавчит махчин амьтан Сфинксээс ангижруулж өгсөн эрд Лайгийн хаан ширээг өгч, бэлэвсэрсэн дүүгээ түүний эхнэр болгох шийдвэр гаргасан аж¹¹.

Сфинксийн аюул, хааных нь үхэл зэрэг давхар гамшигт автсан фивачуудын нутагт хувь заяаныхаа эрхээр өөрөө ч мэдэлгүй хүрсэн Эдип хотынхныг аймшигт Сфинксээс аврахаар зориглож, улмаар таалгасан оньсогыг нь тайлснаараа үнэхээр аварч чадсан аж. Тэгэхэд Лайг нас барсны дараа фивачуудыг хаанчилж байсан Креонт болзон амалсан ёсоороо Эдипийг фивачуудын хаан болгож, бэлэвсэн дүүгээ түүний эхнэр болгожээ.

Эдип улсаа ухаалгаар удирдаж, эрэгтэй эмэгтэй дөрвөн хүүхэдтэй болж, сайхан амьдарч байлаа. Гэтэл Эдипийн алдар нэр улам их мандаж

байсан үед хотынхны дунд тахал өвчин гарч дэлгэрэв. Түүний шалтгааныг төлөгч нар тайлахдаа: "Лай хаан үл таних хүнд алуулсан билээ. Лайгийн сүнс нь гэмт хэрэгтнийг шийтгэж, өшөө авахыг шаардаж байна. Хэрэв Лайг хөнөөсөн хүнийг олж, шийтгэвэл тахал өвчин устгах болно" гэжээ. Эдип үүнийг сонсоод Лай хааныг хөнөөсөн хүнийг мэдэхийн тулд хамгийн сайн төлөгч Тиреси гэдэг нэгэн хараагүй хөгшнөөс лавлатал тэр нь Эдипт аймшигт үнэнийг хэлэх эсэхээ зориглохгүй цааргалж байсан ч шахан шавдуулсны эцэст арга буюу үнэнийг хэлэв. Ийм үнэнийг мэдсэн Жокаст гашуудлаа тэссэнгүй өөрийгөө өгүүтгэж, Эдип өөртөө хорсохдоо хоёр нүдээ сохолж, хаан ширээгээ орхиж, улсаасаа гаран тэнэх зам сонгосон аж.

Ф.Ницшегийн тайлбарлаж байгаагаар Эдип бол цэцэн ухаалаг боловч байнгын төөрөгдөл, зовлонтой байх хувь тавилантай, нимгэрдэггүй зовлон нь түүнийг өөрийг нь гэсэн бүхэнд шидэт буян болж, түүний үхсэн хойно нь ч гэсэн тэр буян нь хадгалагддаг тийм сурвалж сайт хүний жишиг мөн. Сурвалж сайт хүн хилэнцийг тэвчдэггүй. "...Тийм хүний үйлдлээс аливаа хууль, байгаль ёсны аливаа дэг журам, түүгээр зогсохгүй зан суртахууны ертөнц үгүй болтугай. Учир нь, түүний үйлдлийн үр дүнд нөлөөний илүү шидэт хүрээ тогтож, тэр нөлөө нь өмхөрсөн хуучин ертөнцийн буурин дээр шинэ ертөнц бүтээдэг"¹²

Эдип бол эцгээ хөнөөгч, эхийнхээ нөхөр, Сфинксийн оньсыг таагч болж буй ийм гурван нууцлаг яадал бидэнд юуг хэлээд байна вэ? гэсэн асуултыг Ф.Ницше тавиад өөрөө хариулахдаа: "Энэхүү хоёр дүрт Сфинкс болох байгалийн оньсыг таах гэж шийдсэн хүн бол байгалийн хамгийн нандин хууль ёсыг зөрчиж, энэ нь эцгийгээ алж, эхийнхээ ханилсан нөхөр нь болох лугаа адил байх юм"¹³ гэсэн буй. Эдип зориг гарган Сфинксийг шийдэмгий ялснаараа өнгөн дээрээ их хожсон мэт байгаа ч хэрэг дээрээ зүүдэнд ч оромгүй гутамшигтай хилэнц үйлдсэн лүгээ адил тийм байдалд хүн төрөлхтөн байгальтай харьцахдаа орох вий гэсэн утгатай ноцтой сэрэмжүүллийг Ф.Ницше нэг биш удаа хийсэн байна. Иймд байгалийг захирч, эзэмдэхийг уриалдаг аливаа сургаалд Ф.Ницше шүүмжлэлтэй хандаж, байгалийн нууцыг танин мэдэх нь хүн төрөлхтөнд гай тарихаас сайн юм өгөхгүй гэж үзжээ

Оюун ухаан, шинжлэх ухааныг шүүмжилсэн нь. Ф.Ницше: амьдралын аз жаргал бол галзуу согтуу юм, жинхэнэ аз жаргал гэгч байхгүй юм гэдэг А.Шопенгауэрийн үзлийг баримтлаад уг үзлийг нотлох гол хэрэгслийг Сократ, Платон, Аристотель нарын үеийн урлаг биш, харин Сократаас өмнөх урлаг мөн гэж үзсэн байна. Сократаас өмнийн Грект "дионисон сэтгэл санаа" ноёрхож, гэхдээ түүнтэй зэрэгцээд бас "аполлонон сэтгэл санаа" өсөж, бэхжиж байсан гэж Ф.Ницше "Трагедийн төрөлт ..." зохиолдоо бичжээ. Эртний грекчүүдийн сэтгэл санааны хоёр үндсэн хэв маягийн эдгээр тодотгол уг нь тэдний шидэт домог дахь хоёр бурхан тэнгэрийн нэрнээс гаралтай¹⁴. Үүнд, Дионис бурхан тэнгэр бол гол нь газар тариаланг тойрсон янз бүрийн үйл хариуцан эрхэлж, энэ дэлхий дэх байгалийн элдэв хүчтэй холбоотой байж, өөрийгөө хаа сайгүй шүтүүлэхийн төлөө тэмцэгч тийм бурхан тэнгэр мөн. Дионис бол Аполлонтой ямагт тэрсэлддэг. Аполлон бол нэн түрүүнд овгийн язгууртны бурхан тэнгэр байснаа гэрэл ба нарны, бүр хожмоо шинжлэх ухаан, урлаг зэрэг мэдлэгийн бурхан тэнгэр болжээ. Тийнхүү Дионис нь инстинктив, урсгал эрч хүчийг;

харин Аполлон нь тогтонги, хэм хэмжээлэг, оюун санаалаг байдлыг төлөөлдөг.

Хүн төрөлхтний иргэншлийн анхны шатуудад шинжлэх ухааныг бодвол урлаг тэргүүлэх ач холбогдолтой байсан гэж Ф.Ницше үзэхдээ тэдгээр үеийн урлаг бол "хоосон мөрөөдөл(иллюзи) рүү сайн дураараа тэмүүлэхүй" байлаа гэж дүгнэсэн байна. Тийм урлагт дионисон ба аполлонон хэмээх хоёр зарчим тэгш эрхтэй байж, хоорондоо өрсөлдөн зөрчилдөж байсан гэж заах зорилтыг Ф.Ницше "Трагедийн төрөлт..." зохиолдоо тавьсан байна. Тэрээр өөрөө дионисон зарчимд нь илт талтай байж, Сократаас өмнөх үеийн урлагт уг зарчим ноёрхон байсныг сүрлэгээр тайлбарладаг. Энэ нь: амьдрал бол байгальтай салшгүй холбоотой хурц мэдрэмж, бүтээгч догшин энерги, инстинктив эрдүү хүч мөн гэж Ф.Ницше үздэгтэй уялддаг.

Харин түүний харамсан тэмдэглэснээр Сократ, Платон нарын үйл ажиллагааны уршгаар Грекийн урлагт аполлонон зарчим давамгайлах болж, улмаар урлагийг бодвол шинжлэх ухаан илүү үнэлэмжтэй болж эхэлжээ. Ийм байдал цаашдаа Европын нийт соёлд халдварлан, орчин үеийн урлагт дионисон сэтгэл санаа дарагдмал болсон аж. Тэгээд Ф.Ницше: "дэлхий дээр Сократ анх удаа сэтгэхүйн гүн боловсруулалттай хүслэн ба хоосон мөрөөдөл бий болгосон. Энэхүү хүслэн ба хоосон мөрөөдөл бол: ахуйн гүн ёроол руу шалтгаацлын хуулиар удирдуулсан сэтгэхүй нэвтэрч чаддаг бөгөөд энэхүү сэтгэхүй нь ахуйг танин мэдэх төдийгүй бас тэгээд түүнийг засах ч чадвартай гэдэг бат бишрэл мөн. Энэхүү тансаг ариун метафизик хүслэн аваас шинжлэх ухаан угаас инстинкт төлөвтэй байж, шинжлэх ухааныг өөрийнх нь зах хязгаар луу ахин дахин шахаж, тэнд нь шинжлэх ухаан урлаг болж хувирах тулгалтад ордог бөгөөд ийм тулгалт бол энэ механизмын өөрийнх нь зорилго байсаар иржээ"¹⁵ гэж бичсэн байдаг.

Сократ, түүнийг баримтлагч(Платон зэрэг) сэтгэгч нарын тухай Ф.Ницшегийн үнэлгээ дор хаяж дараахь хоёр санааг илэрхийлдэг. Үүнд: нэгдүгээрт, шинжлэх ухаан бол үнэнийг нээгч биш, харин үнэнийг хайгч, иймд эцсийн үр дүнгээрээ урлагийн адил бас хоосон мөрөөдөл мөн. Хоёрдугаар, шинжлэх ухааны ариун хүслэн, хоосон мөрөөдөл инстинктээс гаралтай байдаг тул тэр(шинжлэх ухаан) нь эцсийн эцэст урлагийн бүтээл болж хувирдаг аж. Тийнхүү Ф.Ницше урлагийг шинжлэх ухаанаас ямагт дээгүүр тавьж, шинжлэх ухааныг урлагт зөвхөн дөхөж буй оюун ухааны мэдлэг байдлаар тайлбарлажээ. Тэрээр Сократ, Платон нарыг "хуурамч грекчүүд", "грек тэрсүүнүүд" гэх мэтээр нэрлэсэн. Диалоги аргыг(диалектикийг) үүсгэн боловсруулсан Сократ, Платон нарт Ф.Ницше тийнхүү иррационализмыг хамгаалсан зэвүүцэл илэрхийлдэг.

Үүний сацуу тэрээр оюун ухааны мэдлэгийн зохих ач холбогдлыг үгүйсгэж чадаагүй юм. Сократ бол "шинжлэх ухаан дахь сая дурдсан инстинктээр удирдуулаад амьдарч чадсан төдийгүй харин ч илүүтэйгээр үхэж чадсан анхны хүн мөн. Мэдлэг, учирлаараа үхэхээс айхаас чөлөөлөгдсөн хүн болох үхэж буй Сократын дүр бол шинжлэх ухааны хаалган дээрх сүлдэт хамгаалалт мөн"¹⁶. Хэдий тийм боловч: оюун ухаан бол амьдралын эмгэнэл ба өвчин зовлонг арилгах эм болж чаддаггүй төдийгүй бас нэг төрлийн өвчин мөн. Иймд оюун ухаан бол буян, эрүүл мэнд, аз жаргал зэрэг рүү хөтлөгч биш гэж Ф.Ницше бичсэн байдаг.

Ийнхүү Ф.Ницше "Трагедийн төрөлт буюу эллиний соёл ба пессимизм" хэмээх бүтээлдээ апполонон(өөдрөг баясгалант, логик ангилалт, сайхан) ба дионисон(эмгэнэлт шүтээнт, мансуу амьдралт) хэмээх эсрэг тэсрэг хоёр эхлэл зарчмын өрсөлдөөн бол хүн төрөлхтний бүх түүхийг нэвчиж ирсэн гэсэн арга зүйн баримжааллыг мөрджээ. Тэгээд: Сократаас эхлэн шинжлэх ухааныг чигээ болгосон соёл үүсэж, хөгжих болсон нь бүхнийг бүдүүвчлэн загварчлагч оюун ухааныг түшиг тулгуур болгосон хэрэг юм. Иймд энэ соёл амьдралын инстинктив үндсэнд харшилж, амьдралын бүрэлдлийг тасалдуулан, амьдралыг гутаамал загварт оруулж байдаг. Орчин үеийн соёл амьдралыг эвдэгч ийм хүч болж буйг зогсооё гэвэл Сократаас өмнөх үед Грект ноёрхож байсан дионисан зарчим бүхий урлагийг орчин үеийн соёлын үндэс болгох хэрэгтэй гэж Ф.Ницше үзсэн юм. Чухам тийм соёл аваас амьдралыг яг байгаагаар нь, өөрөөр хэлбэл эмгэнэлт, мухар сохор урсгал хүчний тасралтгүй бүрэлдэл болгож харуулна гэж Ф.Ницше найдсан аж. Улмаар энэ санаагаа "Заратустра ингэж өгүүлэв" гэдэг бүтээлдээ гүнзгийрүүлэн дэлгэрүүлж илэрхийлжээ.

Ф.Ницшегийн "Трагедийн төрөлт..." гэдэг бүтээл хэвлэгдсэн даруйгаасаа үнэн ба шинжлэх ухаанд тоомжиргүй хандсанахаа улмаас олон тооны судлаачийн шүүмжлэлд өртсөн ажээ. Хэдий тийм авч Ф.Ницше иррационалист баримтлалаасаа ухраагүй байна. Тэгээд "Трагедийн төрөлт..." зохиолыг шүүмжилсний хариу болгож "Цагаа олоогүй тунгаан бодохуй" гэдэг ерөнхий нэрийн дор соёл судлалын сэдэвт шүүмжлэлт олон эсээ1873-1876 оны хооронд бичсэн аж.

Тухайлбал 1873 онд бичээд 1874 онд хэвлүүлсэн "Амьдралд түүхийн шинжлэх ухааны учруулдаг ашиг ба хорын тухай" гэдэг зохиолдоо¹⁷ түүхийн мэдлэгийн тодорхой төрлийн ач холбогдлыг зөвшөөрсөн боловч бүхэлдээ түүхийн мэдлэгийн хор уршгийн тухай өгүүлж, энэ үйл ажиллагаа нь иррационализмыг рационализмаас дээгүүр тавихад захирагджээ. Үүнд, түүний бичсэнээр түүхийн баримт байгаагаараа битүү, мохоо байдаг. Харин түүнд янз бүрийн онол ба тайлбар л утга(ир) оруулдаг. Энэ нь баримтыг гуйвуулж, түүх бүтээх үзэлд(историцизмд) хүргэдэг. Ийм зохиомол түүхэнд итгэгч нар амьдралын инстинктив эрчмээ алдаж, хэт эрт буурь сууж, өөрийн бодолгүй болж, улмаар засгийн газар, бүхэл бүтэн үндэстэн хүртэл орчин үеийн мэдрэмжээ алдаж, орчин үеэрээ амьдарч чадахгүйд хүрдэг.

Энд жишээ болгож Ф.Ницше эгоизм(өөрийгөө шүтэх үзэл) түүхэнд ямар үүрэг гүйцэтгэдгийг тайлбарласан байна. Үүнд,¹⁸ түүхэн янз бүрийн хөдөлгөөний хөшүүрэг нь тус тус хүний юмуу бүлгийн эгоизм байж ирсэн. Иймд ирээдүйн түүхийн барилга ч гэсэн эгоизмыг сууриа болгож таарна. Энэ бол ухаалаг биш эгоизм байхгүй, харин өөрийгөө бэхжүүлэхийн тулд өөртөө тодорхой хязгаар тавьдаг тийм ухаалаг эгоизм байх юм. Ухаалаг эгоизм өөрийгөө ард түмэн ба ажилчдын ухаалаг биш эгоизмын тэсрэлтээс хамгаалахын тулд төрд, түүний цэрэг ба цагдаад онцгой хамгаалах үүрэг оногдуулах ёстой. Бас ухаалаг биш, аюултай ард түмэнд түүхийг эзэмшүүлэх үндсэн дээр тэдний болхи инстинкт ба шуналыг нь дарж, улмаар тэдгээрийг нь сайтар боловсруулсан эгоизмын голдирол руу оруулах ёстой.

Ийнхүү Ф.Ницше: түүх(хэрэг дээрээ түүхчлэх үзэл буюу зохиомол түүхэн мэдлэг) нэгэнтэйгүүр ялангуяа залуу үеийг эрч хүчгүй болгож, нөгөөтэйгүүр олон түмний эвдэгч урсгал хүчийг сааруулагч тийм хоёр талтай

гэж үзжээ. Тийм аваас түүхийн мэдлэг эерэг ба сөрөг аль ч нөлөөг үзүүлэхдээ ямагт тогтоон баригч, саатуулагч шинжтэй байж таарна. Гагцхүү тэр шинж зарим нөхцөлд эерэг, өөр зарим нөхцөлд сөрөг ач холбогдолтой байх аж.

Ф.Ницшегийн бүтээлд дараахь санаа нэвт байдаг. Үүнд, **"түүхийг загцхүү хүчтэй бие хүмүүс гаргаж тавьдаг бөгөөд түүх харин доройчуудыг бүрэн дардаг**. Шалтгаан нь гэвэл бидний мэдрэмж ба сэрэл өнгөрсөнтэй хүч үзэлцэх чадвар хангалтгүй буй нөхцөлд түүх тэдгээрийг хэлэх үггүй болгодог"¹⁹. Хүн өөртөө итгэхээ болиод, түүхээс сургамж авах гэхлээрээ айж болгоомжилсон нөхцөлд нэг төдийгүй заримдаа хэд хэдэн үйлийг сонгодог. Угтаа өнгөрсөн бол маш өргөн, урт хүрээтэй тул тухайн тайлбар, тухайн дүгнэлтэнд чухал баримт нэн олон янзаар олдохоор байдаг. Гагцхүү сод ухаантнууд өнгөрсний доторхи агууг, танин мэдвэл зохих зүйлийг илрүүлж чаддаг. Зөвхөн тэдний бүтээлийг жинхэнэ түүх гэж уншиж, түүнээс орчин үеийн хүч олдог байх ёстой.

Ф.Ницше гурван төрлийн түүхэн мэдлэг байдаг гэжээ. Үүнд: 1.Хуучны ховор нандин юмны(антиквари) түүх. Энэ бол юмыг яг өнгөрсөн уламжлалаар нь сэргээдэг түүх мөн. 2.Бүтээгч (монументаль) түүх. Энэ бол өнөөгийн зорилтоо биелүүлэхдээ өнгөрснөөс загвар, үлгэр олж авдаг түүх мөн. 3.Шүүмжлэлт түүх. Энэ бол өнөөгийн зорилтоо хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээлээ амжилттай туулахын тулд өнгөрснөө хянаж, шүүдэг түүх мөн. "Түүхийн ийм гурван маяг тус бүр гагцхүү тодорхой хөрсөнд, тодорхой уур амьсгалд зүй ёсоор хөгжиж чадах бөгөөд харин тэдгээр нь тохирохгүй ямар ч хөрсөнд бол ургацыг балладаг хог өвс төдий болж хувирдаг"²⁰ажээ.

Амьдрал бол түүхийн илүүдлээс шалтгаалан зохицолдоот хүчгүй болон өвчилж, ингэснээрээ тэр(амьдрал) нь өнгөрснийг цэвэр хүнс болгон ашиглаж чадахаа больсон үед ялангуяа залуу хүн эрүүл диваажингаа сэргээх гол хоёр эм байдаг хэмээн Ф.Ницше үзжээ. Тэдгээр нь түүхэн биш, зүйл, түүхээс дээгүүр зүйл аж. "Би "түүхэн биш зүйл" гэдэг үгээр урлаг, бас **мартах** ба тодорхой хязгаардмал **хүрээнд** түгжигдэх чадварыг тэмдэглэдэг"²¹ хэмээн тэрээр бичжээ. Жишээ нь, түүхийн мэдрэмж тодорхой төвшинөөс хэтрэх юм бол бодгаль хүн, бүхэл бүтэн ард түмэн, бас соёл бүхэлдээ ихээхэн хохиролд нэрвэгддэг төдийгүй мөхөхөд хүрдэг гэж Ф.Ницше өгүүлсэн юм. Тийм төвшнийг тогтоож, өнгөрснийг мартах хязгаарыг тогтооё гэвэл бодгаль хүн, ард түмэн, соёл аль алины зохицолдоот хүч ямар байгааг, өөрөөр хэлбэл тэдгээр тус бүр нь өөрөө өөрөөсөө өсөх, өнгөрсөн ба харийн зүйлийг нэвтрүүлэн шингээх, алдсанаа нөхөх, эвдэрсэн хэлбэрүүдээ өөрөөсөө сэргээх зэрэг чадвар ямар байгааг тогтоох ёстой ажээ.

Мөн аливаа амьтан хэт амиа бодоод, бусдын хүрээ рүү түрэмгийлэхээрээ эцэж, сульдана, улмаар цагаасаа өмнө үхдэг. "Хөөр хөгжөөн, тохирсон нүнжиг, аз жаргал авчирдаг үйл ажиллагаа, ирээдүйдээ итгэхүй зэрэг бол нэг хүн ч бай, ард түмэн ч бай аль алины хувьд түүнд харж болох зүйлийг, гэрлийг битүү юмнаас, харанхуйгаас ялгах чиг шугам байна уу гэдгээс хамаарч, тэр бас цагий нь онож санадаг шигээ цагий нь онож мартаж чаддаг уу гэдгээс хэзээ түүхчлэн мэдрэх, хэзээ түүхчилэхгүйгээр мэдрэх ёстойгоо тодорхойлох эрүүл инстинктийн чадвартай эсэхээс тус тус хамаардаг. Иймд ... **нэг хүн, ард түмэн, соёлын эрүүл мэндэд түүхэн ба түүхэн биш зүйл адилхан чухал**"²²

Гэвч Ф.Ницше түүхэн биш ба түүхээс дээгүүр зүйл хоёрыг түүхээс илүү чухалчилдаг болохыг бид тогтон авч үзлээ. Тэрээр: "Мөнх ба үл өөрчлөгдөх шинж байдгийг ахуйд мэдээлэхэд, шууд хэлбэл **урлаг, шашин** хоёрт бидний анхаарлыг төвлөрүүлээд, тэр анхаарлыг бүрдлийн явцаас хөндийрүүлдэг хүчнүүдийг би "түүхээс дээгүүр зүйл" хэмээн нэрлэж байна"²³ гэж бичжээ. Тийнхүү Ф.Ницше бүрэлдэл, мөнх биш, өөрчлөлтийг авч үзэхээс зайлсхийж буй нь тэрээр өнгөрсөнд, түүхэнд нэн болгоомжтой ханддагтай уялдаж байна. Харин урлаг, шашин хоёр мөнх, үл өөрчлөгдөх хүчийг мэдээлдэг гэж Ф.Ницше тайлбарладаг.

Ф.Ницше шашныг түүхээс дээгүүр зүйлд хамааруулсны сацуу түүнд нэн шүүмжлэлтэй хандсан. Ийм хандлагыг ялангуяа христос шашинд хүчтэй гаргажээ. Тэрээр ёс суртахуун(мораль) бол амьдралыг буруутгагч хүчин зүйл мөн гэж үзээд аморализмыг сурталчилсныг өмнө дурдсан билээ. Чухам ийм байр сууринаасаа: "...христос шашин анхнаасаа, уг үндсээрээ амьдралд гутсан, амьдралд пологтсон байдал байж, гэхдээ "өөр", "шилдэг" амьдралд сүсэглэсэн гоёлоор өөрийгөө далдлан нууж ирлээ"²⁴. Энэ шашны ёс суртахуун бол "амьдралыг үгүйсгэхийн төлөө хүсэл эрмэлзэл" мөн гэж үзсэн ажээ. Ийнхүү Ф.Ницше философи үйл ажиллагааныхаа эхэн үед буюу А.Шопенгауэрийн шууд нөлөөнд байсан үедээ хүн төрөлхтөний оюуны соёлын зарим чухал бүрэлдэхүүнийг амьдралд ямар ач холбогдолтой байдгийнх нь үүднээс авч үзжээ. Тэгээд тэрээр иррационализмыг тунхагласан дүгнэлтүүд гаргасан байна.

Ном зохиол

- 1.К.А.Свасян. Фридрих Ницше: мученик познания. Вступительная статья. —Фридрих Ницше. Сочинения в двух томах. Том1. М., "Мысль", 1990, с.5-7
- 2.См. об этом: там же, с.7
- 3.См. об этом напр: Джованни Реале и Дарио Антисери. Западная философия от истоков до наших дней. СПб., ТОО ТК "Петрополис", 1997 с.266
4. См. об этом: там же
- 5.Фридрих Ницше. Так говорил Заратустра. Книга для всех и ни для кого. — Фридрих Ницше. Сочинения в двух томах. Том 2. М., Мысль, 1990, с.18
- 6.Ж.Делезийн Парист хэвлүүлсэн энэ ном интернетэд байрладаг бөгөөд бас түүний гол агуулгатай танилцах боломж олгодог бүтээл: Постмодернизм. Энциклопедия. Мн.: Интерпрессервис; Книжный дом. 2001, с.518-520
- 7.Цит. по: там же, с.520
- 8.Эдгээр бүтээлийг: Фридрих Ницше.Сочинения в двух томах. Т.1, М.,1990 номноос үзнэ үү.
- 9.Там же, с.53-54
- 10.Эдип хааны домог олон хувилбартай байдаг. Миний ашигласан хоёр хувилбар: Н.А.Кун.Легенды и миф древней Греции.Мн., 1989, с.428-439; Нийслэлийн сонин бичиг. 2001 оны 11-р сар №17, 18; 5дахь нүүр
- 11.Лай хүүхэд хулгайлсны шийтгэл болгож хаанчилж буй хотод нь Гера зэрэг зарим тэнгэр нар аймшигт махчин Сфинксийг суурьшуулаад, түүнд зааж өгсөн оньсыг уг хотынхон таатал нь тэр араатанг тэнд байлгаж, нөгөөх оньсыг таах үүрэгтэй очоод чадаагүй хүн бүрийг Сфинксээр бариулдаг байхаар тогтсон тухай домгийг: Мифы народов мира. Энциклопедия. Т.2,М., 1998, с.479-480 дахь талтай танилцана уу.
- 12.Фридрих Ницше. Сочинения в двух томах. Т.1, с.89
- 13.Там же, с.90
- 14.Аполлон, Дионис хоёр бурхан тэнгэр тус бүрийн шидэт домог: Мифы народов мира. Энциклопедия. Т. 1, М., 1998 номонд буй.

15. Фридрих Ницше. Сочинения в двух томах. Т.1, с.114
16. Там же,
17. Там же, с.158-230
18. См. об этом: там же, с.220-221
19. Там же, с.189
20. Там же, с.174
21. Там же, с.227
22. Там же, с.164
23. Там же, с.227
24. Там же, с.53